



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”
ТӨХК-Д

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2019.05.08 № 9/2002
танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Хорооны 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 79, 80 дугаар тогтоолоор нэр бүхий үнэт цаасны компаниудын үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаатай түдгэлзүүлэх, мөн өдрийн 81 дүгээр тогтоолоор “Фронтинер ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргасныг үүгээр мэдэгдэж байна.

Хавсралт: Хорооны 2019 оны 79, 80, 81 дүгээр тогтоолын хуулбар.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ДОЛГОРСҮРЭН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот


Нэр бүхий 13 үнэт цаасны компанийн үнэт цаасны
дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, 29.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.1, 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан 13 үнэт цаасны компанийн үнэт цаасны дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгөө Хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын нэгдүгээр хавсралтад заасан хэмжээнд хүргэх талаар холбогдох арга хэмжээг аваагүй тохиолдолд үнэт цаасны дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг хавсралтад нэр дурдсан үнэт цаасны компаниудын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны
4 дүгээр сарын 24-ний өдрийн
79 дүгээр тогтоолын хавсралт

УХА0410 5043239

№	Компанийн нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл
1	"АСЕ энд Т капитал ҮЦК" ХХК	5003164	Дилер, андеррайтер
2	"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	5157234	Дилер, андеррайтер
3	"Монсек ҮЦК" ХХК	2016869	Дилер, андеррайтер
4	"Блумсбюри секьюритис ҮЦК" ХХК	5139104	Андеррайтер
5	"Эм Ай Би Жи ҮЦК" ХХК	5213487	Андеррайтер
6	"Эф Си Икс ҮЦК" ХХК	5173701	Андеррайтер
7	"Эм Ай Си Си ҮЦК" ХХК	5011558	Андеррайтер
8	"Блюскай секьюритиз ҮЦК" ХХК	2057816	Дилер
9	"Гацуурт трейд ҮЦК" ХХК	5464072	Дилер
10	"Батс ҮЦК" ХХК	2027542	Дилер
11	"Зэт Жи Би ҮЦК" ХХК	5469112	Дилер
12	"Өндөрхаан инвест ҮЦК" ХХК	2561077	Дилер
13	"Масдак ҮЦК" ХХК	2786486	Дилер



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот


Нэр бүхий 3 үнэт цаасны компанийн үнэт цаасны брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, 29.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.1, 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад нэр дурдсан 3 үнэт цаасны компанийн үнэт цаасны брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдээгүй тохиолдолд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг хавсралтад нэр дурдсан үнэт цаасны компаниудын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны
4 дүгээр сарын 24-ний өдрийн
80 дугаар тогтоолын хавсралт

УХА0410 50:3239

№	Компанийн нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл
1	“Аргайбэст ҮЦК” ХХК	2071649	Брокер, дилер
2	“Алтан хоромсог ҮЦК” ХХК	2030055	Брокер, дилер
3	“Блэкстоун интернэйшнл ҮЦК” ХХК	5457637	Брокер, дилер



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот


Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Фронтинер ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Компанийн оноосон нэрээс “ҮЦК” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөхийг “Фронтинер ҮЦК” ХХК-ийн удирдлага, эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

3. “Фронтинер ҮЦК” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.



С.ДАВААСҮРЭН